

ХАСБАНК ХК-ИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /Маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Үнэт цаас гаргагчийн нэр: ХасБанк ХК УБГД: 9007001007 Үнэт цаасны симбол: ХАС Утасны дугаар: +976-75771888	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү	
Хагас жилийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Бүртгүүлсэн огноо: 2013 оны 01 дүгээр сарын 23	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа	
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Б.Буяннэмэх /Олон улсын санхүүжилтийн хэлтсийн ахлах шинжээч/ Хянасан: Г.Тамир /Санхүү хариуцсан захирал/ Хянасан: Н.Мөнхцэлмэг /Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт Орлогын тайлан Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн гүйлгээний тайлан	2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Хавсралт №1-д оруулав.
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт	
	2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн хараат бус аудитор хянах ажил хийгдэж байна.	
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт	

3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Ашигт ажиллагаа: 2026 оны эхний хагас жилийн байдлаар ХасБанкны татварын дараах цэвэр ашиг 88.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 хувиар өсжээ. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 20.0 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 168.1 төгрөгт хүрлээ. Нийт зээл: Тайлант хугацаанд зээлийн өсөлт мэдэгдэхүйц эрчимжиж нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 4,889.3 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 16.9 хувиар өссөн байна. Үүнд: • Иргэдийн зээлийн багцын хувьд 11.5 хувиар өсөж, 2772.2 тэрбум төгрөгт хүрсэн. Тус багцын өсөлтөд бичил, жижиг дунд бизнесийн зээлийн багц 28.2 хувиар, ипотекийн зээлийн багц 20.0 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна; • Байгууллагын банкны зээлийн багц 15.4 хувиар өсөж 940 тэрбум төгрөгт хүрсэн; • Бизнесийн банкны зээлийн багц 44.2 хувиар өсөж 323.5 тэрбум төгрөгт хүрсэн; • Хаслизингийн санхүүгийн түрээсийн багц 29.6 хувиар өсөж, 854 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тайлант хугацаанд зээлийн багц эрчимтэй өссөн хэдий ч активын чанарын удирдлагыг оновчтой хэрэгжүүлснээр нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн харьцаа тогтмол 2.2 хувь гарсан нь банкны системийн тэргүүлэх үзүүлэлт юм. Харилцагчаас татсан эх үүсвэр: ХасБанк нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Мөн активын тогтмол өсөлттэй уялдуулан банкны дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Ирээдүйн өсөлт залуусын хадгаламж” болон гадаадад байгаа иргэдэд чиглэсэн “Орон сууцны хадгаламж”-ийн бүтээгдэхүүнүүдийг шинээр зах зээлд нэвтрүүллээ. Үүний үр дүнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар банкны нийт харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах болон хадгаламжийн үлдэгдэл 4,025 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 7.4 хувь өссөнөөр I улирлын уналтыг бүрэн нөхөж улирлын дээд хэмжээнд хүрлээ. Харилцах дансны үлдэгдэл улирлын шинжтэй бууралтын дараа өмнөх улирлаас 28.6 хувиар өссөн нь багцын өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн бол хугацаатай хадгаламж 6.5 хувиар, ирээдүйн саятан хадгаламж 3.4 хувиар тус тус өссөн байна. Гадаад эх үүсвэр: 2026 оны эхний хагас жилд 2025 оны 12 сард FMO-тай байгуулсан синдикат зээлийн гэрээний хүрээнд 150 сая ам.доллар, шинээр DWM, BlueOrchard байгууллагуудаас 5 сая ам.доллар болон 15 сая ам.доллартой тэнцэх хэмжээний төгрөгийн эх үүсвэр, WaterEquity санхүүгийн байгууллагаас 5 сая ам.долларыг тус тус татан төвлөрүүлээд байна. Ингэснээр нийт гадаад эх үүсвэрийн үлдэгдэл 623 сая ам.долларт хүрч, оны эхнээс 13.7 хувиар өсөв. Мөн ХасБанк Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай 80 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан ба үүний 40 сая ам.долларыг 2026 онд татан төвлөрүүлэх боломжтой. Банк нь татан төвлөрүүлсэн эх үүсвэрүүдийг залуу бизнес эрхлэгчид болон бичил ЖДБ эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн усны нөөцийн тогтвортой менежмент, хамгаалалтыг дэмжсэн ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглана.
-------------	--	---

			Монголбанкнаас тогтоосон байвал зохих хэмжээ	2026-06-30-ны байдлаарх үзүүлэлт
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>12.5%	18.4%
		Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	18.4%
		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>25%	33.3%
		Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	+/- 15% дотор	6.6%
		Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	+/- 30% дотор	6.9%
		Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа	<300%	75.1%
		Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа	<25%	8.1%
3.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Гадаад хүчин зүйлс: 2026 оны эхний таван сард Монгол Улсын эдийн засаг өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Уул уурхай, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарууд бүгд өсөлттэй гарсан бөгөөд үүнээс, уул уурхайн салбар 3.7 нэгж хувийг буюу нийт өсөлтийн 50% орчмыг дангаар эзэллээ. Оюу Толгойн зэсийн олборлолтын өсөлт болон нүүрсний олборлолт ба экспортын хэмжээний өсөлтүүд уул уурхайн өсөлтийг гол тулгуур болов. Мөн түүнчлэн үйлчилгээний салбар 1.9 нэгж хувь, хөдөө аж ахуйн салбар 1.5 нэгж хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн нь худалдаа, тээвэр, санхүүгийн үйлчилгээний идэвхжил, мөн мал аж ахуйн салбарын сэргэлттэй холбогдон тайлбарлагдаж байна. Харин бүтээгдэхүүний цэвэр татвар уналттай гарсан нь татварын хөнгөлөлт, онцгой албан татварын орлогын бууралт зэрэг арга хэмжээнүүдээс хамааралтай байв.		
		Гадаад секторын байдал 2026 оны эхэн үед мэдэгдэхүйц сайжирсан нь БНХАУ-ын эрэлтийн өсөлттэй холбогдон тайлбарлагдаж байна. 2026 оны эхний 5 сард нүүрсний олборлолт өмнө оны мөн үеэс 60 хувиар өсөж, 47 сая тонн-д хүрлээ. Ойрх дорнодын нөхцөл байдлаас шалтгаалан газрын тосны үнийн огцом өсөлтөөс үүдэн БНХАУ-ын нүүрсний эрэлт нэмэгдсэн нь коксжих нүүрсний үнийн өсөлтийг дэмжсэн үйл явдал боллоо. Экспортын орлогын өсөлтийн үр дүнд гадаад валютын нөөц 2026 оны 05 дугаар сарын байдлаар 7.7 тэрбум ам.доллар хүрсэн нь гадаад шокуудаас хамгаалах чухал хүчин зүйл болж байна. Мөн энэ хугацаанд гадаад худалдааны эргэлт 34 гаруй хувиар нэмэгдэж, экспорт 57 хувиар, импорт 8 хувиар өссөнөөр худалдааны тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Гэсэн хэдий ч олон улсын байгууллагууд дунд хугацаанд Монгол Улсын төлбөрийн тэнцлийн урсгал дансны илүүдэл буурна гэж таамаглаж байна. Учир нь нүүрсний үнэ аажмаар хэвийн түвшинд буцаж, дотоодын эдийн засгийн сэргэлттэй уялдан импортын эрэлт өндөр хэвээр байх, мөн засгийн газрын болон төрийн өмчит компаниудын евробонд, зээлийн төлбөрийн хугацаа давхцаж эргэн төлөлтийн ачаалал нэмэгдэх зэрэг нь гадаад өрийн зардлыг өсгөх төлөвтэй байна.		
		2026 онд дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнийн шокоос үүдэлтэй үнийн дарамт эрчимтэй байна. Инфляц 06 дугаар сарын байдлаар 12 хувь хүрсэн нь өмнө оны мөн үеэс 3.8 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүнс согтууруулах ундааны бүлэг нийт инфляцын талаас илүү хувийг бүрдүүлж байгаа бөгөөд ялангуяа махны үнийн өсөлт нийт		

өсөлтийн 40%-ийг дангаар бүрдүүлж байна. Энэ нь дотоодын эрэлтийн түүхэн дээд хэмжээ, болон экспортын эрэлт ихэссэн зэрэгтэй холбоотой юм. Харин түлшний үнийг ОХУ-тай хийсэн хоёр талын хэлэлцээрийн ачаар харьцангуй тогтвортой барьж чадсан байна.

Хүнсний үнээс шалтгаалсан үнийн шок цалин хөлс болон нийт инфляцын хүлээлт рүү даамжран нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МонголБанк бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах төлөвтэй байна. Мөнгөний хатуу бодлого болон мал аж ахуйн дотоодын нийлүүлэлт хэвийн түвшинд очсоноор Төв банк инфляцын түвшинийг буурах хүлээлтэй байгаа бөгөөд богино хугацаанд 6 ± 2 дунд хугацаанд 5 ± 2 нэгж хувийн түвшин руу аажмаар буурна гэж үзэж байна.

Дотоод хүчин зүйлс:

Тайлант хугацаанд банкны салбарын дижитал шилжилт эрчимжиж, харилцагчдын санхүүгийн хэрэгцээнд нийцсэн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ХасБанк олон талт арга хэмжээг хэрэгжүүлэв. Цахим төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор орчин үеийн төлбөрийн шийдлүүдийн нэг болох Google Pay үйлчилгээг нэвтрүүлж, ХасБанкны бүх төрлийн Visa дебит картыг холбон, гар утсаараа өдөр тутмын худалдан авалтын төлбөр тооцоог хурдан, найдвартай, аюулгүй гүйцэтгэх боломжийг харилцагчдад бүрдүүлэв. Мөн харилцагчид дижитал банкаараа дамжуулан автомашины торгуулиа төлөх боломжтойгоос гадна бичил, жижиг, дунд бизнесийн зээл болон цалингийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг өөрийн санхүүгийн нөхцөлд тохируулан зохиох, эсвэл хойшлуулах боломжийг бий болгосноор үйлчилгээний уян хатан байдлыг сайжрууллаа.

7-17 насны хүүхдүүдэд зориулсан ХасTeen+ application-ын шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлж, харилцагч хүүхдүүдийн бүртгэл хийх үйл явцыг хялбаршууллаа.

Мөн харилцагчдын урт хугацааны санхүүгийн зорилгыг дэмжих, тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх стратегийн хүрээнд гадаад улсад ажиллаж, амьдарч, суралцаж буй Монгол Улсын иргэдэд эх орондоо эргэн ирж, орон сууцтай болох санхүүгийн зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн “Гадаадад суугаа иргэний орон сууцны хадгаламж” бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгож байна.

Банкны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын үйл ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэх зорилтын хүрээнд 2026 оны эхний хагас жилд ХасБанк нь Sila Centre худалдааны төвд шинэ салбараа нээлээ. Шинэ салбар ашиглалтад орсноор харилцагчид банкны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү ойр, хялбар хүртэх боломж нэмэгдэж, худалдаа, үйлчилгээний төвлөрсөн бүсэд байрлах давуу талаараа иргэд болон бизнес эрхлэгчдэд банкны үйлчилгээг хүргэх чадавхыг нэмэгдүүллээ. Тус салбар нь дижитал болон уламжлалт банкны үйлчилгээг хослуулан хүргэж, тав тухтай орчин, үйлчилгээний чанарыг эрхэмлэн ажиллаж байна.

Монголбанкны 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн мөнгөний бодлогын шийдвэрийн дагуу репо арилжааны хүүг бууруулсан нь банкны салбарын гадаад эх үүсвэрийн өртгийг бууруулахад эерэг нөлөө үзүүллээ.

Банк харилцагчийн сегментээ илүү нарийвчлан, жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуй нэгжүүдэд санхүүгийн цогц үйлчилгээг хүргэх зорилготой Бизнес банкны нэгжийг шинээр бий болголоо. Тус нэгж нь тайлант хугацаанд нийт зээлийн багцын өсөлтийн 14 хувийг бүрдүүлж, банкны бизнесийн зээлийн өсөлт, харилцагчийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулав.

3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	ХасБанкны тэнцлийн гадуурх дансны үлдэгдлийн тайланг Хавсралт №2-д оруулав.																																												
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/																																													
	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлдэг. Дараах холбоосоор орж танилцана уу: https://xacbank.mn/mn/ad-hoc https://mse.mn/mn/company/568 Түүнчлэн, Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг улирал бүр гарган өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Тус тайлантай дараах холбоосоор орж танилцана уу: https://xacbank.mn/financial-highlights Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2026 оны эхний хагас жилд нийт 4 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг баталсан. Ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримталсан. <table><tr><th>№</th><th>Хамаарал</th><th>Хэлцлийн дүн (төгрөг)</th></tr><tr><td>1</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>50,000,000</td></tr><tr><td>2</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>20,000,000</td></tr><tr><td>3</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>30,065,096</td></tr><tr><td>4</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>20,000,000</td></tr></table>		№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)	1	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000	2	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000	3	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	30,065,096	4	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000																													
№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)																																												
1	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000																																												
2	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000																																												
3	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	30,065,096																																												
4	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	20,000,000																																												
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																																													
	Тайлант хугацаанд нэмэлт хувьцаа гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлээгүй болно.																																													
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл																																													
	Хувьцаа эзэмшлийн бүтэц Тайлангийн өдрийн байдлаар ХасБанкны хувьцаа эзэмшигчид дараах бүтэцтэй байна: <table><tr><th>#</th><th>Хувьцаа эзэмшигчид</th><th>Хувьцааны тоо</th><th>Хувь</th></tr><tr><td>1</td><td>МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди</td><td>203,864,933</td><td>19.37%</td></tr><tr><td>2</td><td>Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/</td><td>175,028,025</td><td>16.63%</td></tr><tr><td>3</td><td>ОРИКС Корпораци</td><td>171,366,429</td><td>16.28%</td></tr><tr><td>4</td><td>Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/</td><td>131,543,137</td><td>12.50%</td></tr><tr><td>5</td><td>Канадын Үндэсний Банк /NBC/</td><td>107,194,412</td><td>10.18%</td></tr><tr><td>6</td><td>Ронк Партнерз Кей Эф Ти</td><td>103,459,739</td><td>9.83%</td></tr><tr><td>7</td><td>Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди</td><td>67,531,041</td><td>6.42%</td></tr><tr><td>8</td><td>Олон нийт</td><td>89,859,061</td><td>8.54%</td></tr><tr><td>9</td><td>Халаасны хувьцаа</td><td>2,853,223</td><td>0.27%</td></tr><tr><td colspan="2">Нийт</td><td>1,052,700,000</td><td>100.00%</td></tr></table>		#	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь	1	МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди	203,864,933	19.37%	2	Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/	175,028,025	16.63%	3	ОРИКС Корпораци	171,366,429	16.28%	4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	131,543,137	12.50%	5	Канадын Үндэсний Банк /NBC/	107,194,412	10.18%	6	Ронк Партнерз Кей Эф Ти	103,459,739	9.83%	7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	67,531,041	6.42%	8	Олон нийт	89,859,061	8.54%	9	Халаасны хувьцаа	2,853,223	0.27%	Нийт		1,052,700,000	100.00%
#	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь																																											
1	МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди	203,864,933	19.37%																																											
2	Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/	175,028,025	16.63%																																											
3	ОРИКС Корпораци	171,366,429	16.28%																																											
4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	131,543,137	12.50%																																											
5	Канадын Үндэсний Банк /NBC/	107,194,412	10.18%																																											
6	Ронк Партнерз Кей Эф Ти	103,459,739	9.83%																																											
7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	67,531,041	6.42%																																											
8	Олон нийт	89,859,061	8.54%																																											
9	Халаасны хувьцаа	2,853,223	0.27%																																											
Нийт		1,052,700,000	100.00%																																											

Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн бүрэлдэхүүн



Санжай Гүпта
ТУЗ-ийн дарга



Г.Цэвэгжав
ТУЗ-ийн гишүүн



Майкл Мадден
ТУЗ-ийн гишүүн



Н.Цэлмүүн
ТУЗ-ийн гишүүн



Нираж Вэдва
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Сюзанна Херринг Карр
ТУЗ-ийн гишүүн



Эми Чой
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Стюарт Доналд Холл
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Батсайхан
ТУЗ-ийн гишүүн



Мелисса Мой Тиен
ТУЗ-ийн гишүүн



Ашот Осипян
ТУЗ-ийн гишүүн



Э.Оюунбилэг
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Жич: Гишүүдийн боловсрол, ажлын туршлага зэрэг дэлгэрэнгүй мэдээлэлтэй банкны вебсайтаар дамжуулан танилцах боломжтой.
Дараах холбоосоор орно уу: <https://xacbank.mn/board>

2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх ТУЗ-ийн гишүүдийн ХасБанк дахь хувьцаа эзэмшил:

№	Овог нэр	Албан тушаал	Хувь эзэмшил (шууд)
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	0.12%
2	Г.Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	0.31%
3	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	-
4	Н.Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	-
5	Мелисса Мой Тиен	ТУЗ-ийн гишүүн	-
6	Сюзанна Херринг Карр	ТУЗ-ийн гишүүн	-
7	Б.Батсайхан	ТУЗ-ийн гишүүн	-
8	Ашот Осипян	ТУЗ-ийн гишүүн	-
9	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
10	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
11	Стюарт Доналд Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
12	Э.Оюунбилэг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

Аудитын хороо ("АХ")	Нэр дэвшүүлэх хороо ("НДХ")	Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ")	Засаглал, цалин урамшууллын хороо ("ЗЦУХ")
Дарга: Эми Чой	Дарга: Нираж Вэдва	Дарга: Стюарт Доналд Холл	Дарга: Стюарт Доналд Холл
Ердийн гишүүд: Б.Батсайхан Ашот Осипян	Ердийн гишүүн: Санжай Гүпта Мелисса Мой Тиен	Ердийн гишүүн: Сюзанна Карр Б.Батсайхан	Ердийн гишүүн: Н.Цэлмүүн Майкл Мадден
Хараат бус гишүүд: Э.Оюунбилэг Стюарт Холл Нираж Вэдва	Хараат бус гишүүд: Э.Оюунбилэг Стюарт Доналд Холл Эми Чой	Хараат бус гишүүд: Э.Оюунбилэг Нираж Вэдва Эми Чой	Хараат бус гишүүд: Э.Оюунбилэг Нираж Вэдва Эми Чой

Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

Тайлант хугацаанд ХасБанк нь дараах удирдлагын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулсан:



**Гүмэнжавын
Цэвэгжав**

Гүйцэтгэх захирал



**Ганзоригийн
Эрдэнэбаяр**

Гүйцэтгэх захирлын тэргүүн
орлогч бөгөөд Иргэдийн
банк хариуцсан захирал



Бавааны Еркин

Гүйцэтгэх захирлын орлогч
бөгөөд Байгууллагын банк
хариуцсан захирал



**Серикжаны
Дауренбек**

Гүйцэтгэх захирлын орлогч
бөгөөд Бизнесийн банк
хариуцсан захирал



**Доржпүрэвийн
Мөнхзул**

Лизинг хариуцсан захирал



Ганхуягийн Тамир

Санхүү хариуцсан захирал



Илия Аврамов

Эрсдэл хариуцсан захирал



Энхбаярын Ундармаа

Зээл хариуцсан захирал



Ганзоригийн Зул

Хүний нөөц, захиргаа
хариуцсан захирал



Энэбишийн Уламбаяр

Үйл ажиллагаа хариуцсан
захирал



**Хүрэлбаатарын
Өнөрбат**

Мэдээллийн технологи
хариуцсан захирал



**Нямсүрэнгийн
Мөнхцэлмэг**

Хууль хариуцсан захирал /
ТУЗ-ийн нарийн бичгийн
дарга



**Баттогтохын
Биндэрьяа**

Ерөнхий аудитор

Гүйцэтгэх удирдлагын ХасБанкинд эзэмшиж буй хувьцааны хувь эзэмшлийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар толилуулав:

№	Овог нэр	Албан тушаал	Хувь эзэмшил (шууд)
1	Г.Цэвэгжав	Гүйцэтгэх захирал	0.31%
2	Г.Эрдэнэбаяр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал	0.11%
3	Б.Еркин	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал	0.06%
4	С.Дауренбек	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнесийн банк хариуцсан захирал	0.07%
5	Д.Мөнхзул	Лизинг хариуцсан захирал	0.03%
6	Г.Тамир	Санхүү хариуцсан захирал	0.02%
7	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал	0.00%
8	Э.Ундармаа	Зээл хариуцсан захирал	0.06%
9	Г.Зул	Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал	0.06%
10	Э.Уламбаяр	Үйл ажиллагаа хариуцсан захирал	0.08%
11	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал	0.05%
12	Н.Мөнхцэлмэг	Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0.03%
13	Б.Биндэрьяа	Ерөнхий аудитор	0.01%

7. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ХасБанк нь хувьцаат компани болсноос хойш Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодекст заасны дагуу 2023, 2024 болон 2025 оны хэрэгжилтийн үнэлгээний тайланг бэлтгэн гаргаж тухай бүр Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн.

ХасБанкны “Компанийн засаглалын кодексийн” хэрэгжилтийн 2025 оны тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж 97.2% буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн нь өмнөх оноос 4.1%-иар өссөн үзүүлэлт юм. 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос ХасБанк ХК-ийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг хянан баталгаажуулж, 93%-тай үнэлсэн боловч, ХасБанк ХК-ийн зүгээс тайлангийн зарим шалгуур үзүүлэлттэй холбоотой зохих тайлбарыг нэмж хүргүүлсэнтэй холбоотойгоор 2026 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 97.2%-тай үнэлэгдсэн болно.

“Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2025 оны тайланд СЗХ-ноос өгсөн үүрэг даалгаврын дагуу зохих өөрчлөлтийг хийж, энэ талаарх мэдээлэл, баримтыг 2026 оны хагас жилийн байдлаар СЗХ-нд хүргүүлсэн. СЗХ-ноос хянан баталгаажуулалт хийгдсэний дараа шинэчилсэн тайлан болон үнэлгээг Монголын хөрөнгийн бирж болон өөрийн цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлэн ажиллах болно.

№	Гарчиг	Авбал зохио оноо	2024.12.31-ний байдлаар		2025.12.31-ний байдлаар		Өөрчлөлт хувь
			СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%	11	91.6%	+8.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70%	9	70%	+20%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	6	100%	-
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%	6	100%	-
5	Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	-
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100%	6	100%	-
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	-
8	Компанийн соёл	6	6	100%	6	100%	-
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%	10	100%	-
Нэгдсэн дүн		72	67	93.1%	70	97.2%	+4.1%

Хянан баталгаажуулалтын оноо болон дэлгэрэнгүй тайлантай дараах холбоосоор орж танилцана уу:

<https://mse.mn/mn/company/568>

<https://xacbank.mn/mn/governance-codex-report>

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

ХасБанк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр танхим болон эчнээ санал хураалтын хэлбэрээр амжилттай зохион байгуулагдсан. Хуралд нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчдийн 96.3 хувь оролцсоноор ирц бүрдэж, дараах 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв:

1. ХасБанкны 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. ХасБанкны 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай
3. ХасБанкны 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай

4. Хувьцаа эзэмшигчдийн 2028 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай
5. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай

Эдгээр тогтоолуудтай Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцах боломжтой. Дараах холбоосоор орно уу:

<https://xacbank.mn/mn/shareholders-meeting>

2. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") болон ТУЗ-ийн дэргэдэх хорооны хурал

Банкны ТУЗ нь 2026 оны эхний хагас жилд 2 удаагийн ээлжит хурал болон 4 удаагийн ээлжит бус хурлыг оролцуулан нийт 6 удаа хуралдаж, 2 удаа цахимаар санал хураан, нийт 31 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. ТУЗ-ийн ээлжит хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ТУЗ-д танилцуулдаг.

2026 оны эхний хагас жилд ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, цалин урамшууллын хороо 3 удаа хуралдаж, Нэр дэвшүүлэх хороо 5 удаагийн хурал, 1 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж, Эрсдэлийн удирдлагын хороо 3 удаа хуралдаж, 13 удаа цахимаар санал хураасан бөгөөд Аудитын хороо 5 удаа хуралдаж, ТУЗ-д холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

3. ТУЗ-ийн үйл ажиллагаа

Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн ХасБанкны ТУЗ-өөс 2026 оны эхний хагас жилд дараах журам, төлөвлөгөө, хөтөлбөрийг шинээр баталж, нэмэлт өөрчлөлт оруулж болон шинэчлэн баталсан. Үүнд:

Шинээр баталсан:

1. ХасБанк ХК-ийн эрх бүхий албан тушаалтан болон гүйцэтгэх удирдлагын гишүүний хувьцаа худалдах ерөнхий журам

ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-13 дугаар тогтоолоор ХасБанк ХК-ийн эрх бүхий албан тушаалтан болон гүйцэтгэх удирдлагын гишүүний хувьцаа худалдах ерөнхий журмыг батлагдсан бөгөөд тус журмын зорилго нь ил тод, шударга байдал болон компанийн сайн засаглалыг дэмжих, ашиг сонирхлын зөрчил болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын нийцлийг хангахад оршино. Энэхүү журмаар ХасБанк ХК-ийн гүйцэтгэх удирдлагын гишүүн, эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн холбогдох этгээдийн ХасБанкны хувьцаа худалдахад баримтлах зарчим, дүрэм, үйл ажиллагааг зохицуулна.

2. ТУЗ-ийн 2026 оны сургалтын хөтөлбөр

ТУЗ-ийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн R-2026-31 дүгээр тогтоолоор ТУЗ-ийн түвшинд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ("МУТСТ") өнөөгийн аюул занал, практик схемүүдийг таниулж, технологид суурилсан идэвхтэй хяналтын тогтолцоо руу шилжих замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах шийдвэр гаргахад чиглүүлэх зорилго бүхий "Цаашдын МУТСТ тогтолцооны тухай" сургалтын хөтөлбөрийг баталсан. Тус сургалтын хөтөлбөрийг Санхүүгийн зохицуулах хорооны Компанийн засаглалын кодексын дагуу боловсруулсан.

Нэмэлт өөрчлөлт оруулсан:

1. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм

ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-16 дугаар тогтоолоор Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэн эрхэд тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага болон уур амьсгалтай холбоотой эрсдэлийн удирдлагын бодлого, стратеги, хэрэгжилтийн асуудлыг нэмэх зорилгоор Эрсдэлийн удирдлагын хорооны Дүрэмд холбогдох зохицуулалтыг нэмж оруулсан.

2. Ажилтны зээлийн ерөнхий журам

ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-11 дүгээр тогтоол, 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн R-2026-26 дугаар тогтоолоор Ажилтны зээлийн ерөнхий журамд цалингийн зээлийн нөхцөл, зээл шийдвэрлэх чиг үүрэгтэй холбогдуулан тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.

Шинэчлэн баталсан:

1. ХасБанкны тогтворжуулах төлөвлөгөө

ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн R-2026-15 дугаар тогтоолоор ХасБанкны Тогтворжуулах төлөвлөгөө болон түүнийг ашиглах зааврын хамт Монголбанкны Банкныг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх журамд нийцүүлэн тус тус шинэчлэн баталсан.

4. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга

Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэдэг. ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан “ТУЗ-ийн гишүүд болон ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна жилд 2 удаа бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй.

ХасБанк нь “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг баримтлан өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

5. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа

ХасБанк нь холбогдох дотоод журмын дагуу хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар (+976-8508-1888) болон цахим шуудан (investor-relations@xacbank.mn)-гаар харилцан ажиллаж байна. Түүнчлэн “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам”-д заасны дагуу банкны урт хугацааны үнэ цэнийг бий болгох гадаад болон дотоод оролцогч талуудтай үр дүнтэйгээр харилцаж, хамтран ажиллах чиглэлд анхаарч өөрийн xacbank.mn цахим хуудсаар дамжуулан оролцогч талуудад мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

6. Мэдээллийн ил тод байдал

ХасБанк нь “Мэдээллийг ил тод болгох ерөнхий журам”-ыг баримтлан өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод, тухай бүр тайлагнан ажиллаж байна. Холбогдох мэдээлэлтэй Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудсаар дамжуулан танилцах бүрэн боломжтой.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г. Цэвэгжав

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Тамир

Албан тушаал: Санхүү хариуцсан захирал

Гарын үсэг:

Овог, нэр: Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:

2026 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

	Балансын зүйл	Эхний үлдэгдэл /2025.12.31/	Эцсийн үлдэгдэл /2026.06.30/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,721,509,479,408.51	1,635,184,051,157.19
1.1.1	Бэлэн мөнгө	35,042,395,966.77	40,207,577,659.50
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	646,274,909,703.02	585,666,153,572.39
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1,039,955,655,848.72	1,008,677,866,408.58
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	236,517,890.00	632,453,516.72
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	504,508,163,579.64	496,172,502,539.78
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	504,612,992,753.95	496,280,348,903.69
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	-	-
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	-	-
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(104,829,174.31)	(107,846,363.91)
1.3	Хөрөнгө оруулалт	214,852,960,299.66	255,630,431,406.32
1.3.1	Арилжааны үнэт цаас	-	-
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	146,341,979,417.30	143,372,945,449.71
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	62,508,546,330.72	106,086,771,548.25
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	-	-
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	7,202,650,218.57	7,646,669,473.36
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	(1,200,215,666.94)	(1,475,955,064.99)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	4,182,004,761,089.10	4,884,519,011,694.33
1.4.1	Хэвийн зээл	4,013,989,897,449.47	4,732,874,196,596.66
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	65,988,019,242.47	50,546,913,602.27
1.4.3	Хэвийн бус зээл	14,972,206,070.73	10,177,250,750.12
1.4.4	Эргэлзээтэй зээл	30,294,789,618.07	22,531,229,025.52
1.4.5	Муу зээл	58,006,196,620.24	73,218,609,645.10
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(20,798,671,603.60)	(24,699,861,632.22)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	90,788,725,553.18	96,225,870,511.54
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(71,236,401,861.45)	(76,355,196,804.65)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	46,166,060,621.48	44,350,299,884.99
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	7,755,645,431.02	5,161,577,379.91
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	7,755,645,431.02	5,161,577,379.91
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	-	-
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	-	-
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	93,071,163,618.75	96,738,260,950.85
1.7.1	Бусад тооцоо	61,650,022,522.41	64,980,649,679.66
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	3,028,952,789.84	3,308,379,829.57
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	94,439,362.68	568,357,508.09
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	4,009,040,254.54	6,811,888,505.85
1.7.5	Татварын авлага	139,723,436.08	137,908,128.83
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	11,684,446,907.21	10,357,888,571.60
1.7.7	Бусад	12,464,538,346.00	10,573,188,727.25
1.8	Үндсэн хөрөнгө	75,697,177,542.27	75,675,348,649.82
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	1,586,190,819.76	940,869,435.59
1.11	Биет бус хөрөнгө	14,741,075,187.27	13,731,355,902.04
	Нийт хөрөнгийн дүн	6,861,892,677,597.46	7,508,103,709,000.82
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	853,820,535,750.86	864,637,271,690.59
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	853,057,476,541.41	864,637,271,690.59
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	763,059,209.44	-
2.2	Хадгаламж	2,762,265,744,570.79	2,864,448,955,284.23
2.2.1	Хугацаагүй хадгаламж	215,300,534,974.42	228,233,615,940.35
2.2.2	Хугацаатай хадгаламж	2,516,779,257,066.33	2,606,098,466,857.05
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	14,208,972,433.72	14,297,422,454.15
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	15,976,980,096.33	15,819,450,032.68
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,088,807,177,970.28	2,545,470,711,152.58
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	122,540,880,073.17	282,925,314,889.50

	Балансын зүйл	Эхний үлдэгдэл /2025.12.31/	Эцсийн үлдэгдэл /2026.06.30/
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтгэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,950,910,607,867.80	2,255,824,030,221.93
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(14,946,867,558.27)	(21,974,028,904.59)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	30,302,557,587.58	28,695,394,945.74
2.4	Бусад эх үүсвэр	144,245,999,583.17	152,149,773,871.57
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	-	-
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	-
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	130,320,676,819.30	136,871,711,898.33
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	-	-
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	405,838,898.66	407,282,010.94
2.4.6	Бусад	13,513,131,558.69	14,841,454,701.72
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-	-
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	6,352,306.53	29,325,260.58
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	6,812,173,079.47	3,308,816,570.48
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	73,232,497,870.06	72,949,409,990.63
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	77,778,840,026.62	93,873,812,971.63
2.8	Хоёрдогч өглөг	-	-
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	6,006,962,968,851.26	6,596,838,751,531.69
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	-
3.1.2	Энгийн хувьцаа	105,270,000,000.00	105,270,000,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	28,513,791,266.85	28,358,165,890.75
3.3	Халаасны хувьцаа	(267,281,600.00)	(285,322,300.00)
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	17,869,870,713.95	17,750,980,461.35
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	642,607,008,018.68	698,202,890,294.61
3.6	Бусад өөрийн хөрөнгө	60,936,320,346.72	61,968,243,122.42
3.6.1	Хувьцааны опцион	-	-
3.6.2	Нөөцийн сан	11,439,407,367.49	11,439,407,367.49
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	-
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	46,979,879,698.07	48,242,977,949.48
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	-
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	-
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	-
3.6.8	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний сан	2,517,033,281.15	2,285,857,805.45
3.6.9	Хейджийн хэрэгслийн дахин үнэлгээний сан		
3.6.10	Бусад		
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	854,929,708,746.20	911,264,957,469.13
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	6,861,892,677,597.45	7,508,103,709,000.82

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ✓

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ТАМИР

2026 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

Д/д	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн /2025.12.31/	Тайлант үеийн /2026.06.30/
1	Хүүгийн орлого	846,535,859,928.22	449,476,374,754.20
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	18,694,322,146.14	7,507,505,913.05
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	1,979,247,389.93	316,365,812.06
1.3	Үнэт цаасны	139,854,649,693.80	63,012,420,116.78
1.4	Зээлийн	685,632,093,698.12	378,536,962,760.53
1.5	Бусад хүүгийн орлого	375,547,000.23	103,120,151.78
2	Хүүгийн зардал	544,848,754,467.23	288,140,175,940.36
2.1	Харилцахад төлсөн хүү	7,240,287,601.38	4,873,103,058.96
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	247,642,053,197.30	131,250,956,352.57
2.3	Зээлийн хүүгийн зардал	166,549,371,569.90	76,526,244,666.91
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	984,940,963.15	534,135,488.21
2.5	Бусад хүүгийн зардал	122,432,101,135.50	74,955,736,373.71
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	301,687,105,460.98	161,336,198,813.85
4	Эрсдэлийн сангийн зардал	13,477,952,605.31	5,786,142,061.29
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	84,987,686.23	312,331,706.22
4.2	Үнэт цаасны	-	355,015,422.06
4.3	Зээлийн	13,392,964,919.08	5,118,794,933.01
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	288,209,152,855.67	155,550,056,752.55
6	Бусад орлого	106,083,849,749.55	46,005,765,002.23
6.1	Хүүгийн бус орлого	91,265,844,520.97	44,557,073,765.31
6.1.1	Арилжааны орлого	11,793,850,276.89	7,634,842,733.46
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	8,552,714,131.04	-
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	68,679,715,960.28	36,852,262,476.48
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	2,239,564,152.76	69,968,555.37
6.2	Бусад орлого, олз	14,818,005,228.59	1,448,691,236.92
7	Бусад зардал	170,906,592,974.46	84,065,607,058.68
7.1	Хүүгийн бус зардал	167,290,687,873.91	82,180,378,648.53
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	58,377,539.59	560,087,609.12
7.1.2	Арилжааны зардал	-	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	-	2,132,127,112.68
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	21,189,525,690.43	11,425,953,925.53
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	146,042,784,643.89	68,062,210,001.20
7.2	Бусад зардал, гарз	3,615,905,100.55	1,885,228,410.15
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	223,386,409,630.76	117,490,214,696.10
9	Орлогын татварын зардал	50,790,225,374.18	29,254,721,111.39
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	172,596,184,256.58	88,235,493,584.72
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	172,596,184,256.58	88,235,493,584.72
13	Бусад дэлгэрэнгүй орлого	175,798,117.63	(231,175,475.70)
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт		
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	175,798,117.63	(231,175,475.70)
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт		
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт		
13.5	Бусад		
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	172,771,982,374.20	88,004,318,109.01

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ -2

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

Г.ТАМИР





ХАСБАНКНЫ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2026 оны Зургадугаар сар 30

Өөрийн хоронгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж тологдсон капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	30,388,870,985.26	(29,667,800.00)	18,352,368,952.90	62,214,274,198.01	515,406,908,425.25	731,602,754,761.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	105,270,000,000.00	30,388,870,985.26	(29,667,800.00)	18,352,368,952.90	62,214,274,198.01	515,406,908,425.25	731,602,754,761.42
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	172,596,184,256.58	172,596,184,256.58
Бусад дэлгэрэнгүй орлого					175,798,117.63		175,798,117.63
Өмчид гарсан өөрчлөлт	-	(1,875,079,718.41)	(237,613,800.00)		(1,453,751,968.92)	1,453,751,968.92	(2,112,693,518.41)
Хуваарилсан ногдол ашиг			-	(482,498,238.95)		(47,332,334,871.00)	(47,332,334,871.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-			482,498,238.95	-
2025 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	28,513,791,266.85	(267,281,600.00)	17,869,870,713.95	60,936,320,346.72	642,607,008,018.70	854,929,708,746.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	105,270,000,000.00	28,513,791,266.85	(267,281,600.00)	17,869,870,713.95	60,936,320,346.72	642,607,008,018.70	854,929,708,746.21
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-		88,235,493,584.72	88,235,493,584.72
Бусад дэлгэрэнгүй орлого					(231,175,475.70)		(231,175,475.70)
Өмчид гарсан өөрчлөлт	-	(155,625,376.10)	(18,040,700.00)		1,263,098,251.41	(1,263,098,251.41)	(173,666,076.10)
Хуваарилсан ногдол ашиг			-	-		(31,495,403,310.00)	(31,495,403,310.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(118,890,252.60)		118,890,252.60	-
2026 оны 06-р сарын 30-ны өдрийн үлдэгдэл	105,270,000,000.00	28,358,165,890.75	(285,322,300.00)	17,750,980,461.35	61,968,243,122.42	698,202,890,294.61	911,264,957,469.13

ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ТАМИР



2026 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

	Үзүүлэлт	Өмнөх үеийн /2025.12.31/ ***	Тайлант үеийн /2026.06.30/ ***
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:		
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	223,186,657,558.97	116,086,597,868.60
1.2	Орлого, зардлын тохируулга:	(271,579,947,006.42)	(144,429,477,640.48)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	11,700,713,085.00	5,899,755,574.42
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	20,093,317,538.29	11,123,797,700.34
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	-	-
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(846,535,859,928.22)	(449,476,374,754.20)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	544,848,754,467.23	288,140,175,940.36
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	(1,686,872,168.73)	(116,832,101.40)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	-	-
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	(725,531,119,621.89)	(400,863,021,052.81)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(106,509,722,469.88)	8,332,643,850.26
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	-	-
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(687,405,855,453.99)	(706,152,264,503.99)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(28,080,445,628.28)	4,072,132,902.10
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(30,661,226,845.32)	(2,892,321,794.25)
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	262,025,615,519.52	113,920,535,926.26
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	(153,242,695,968.48)	166,332,182,869.82
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	2,053,738,392.61	1,143,181,001.40
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	16,289,472,831.93	14,380,888,695.59
1.4	Бусад тохируулга:	211,231,126,890.16	126,771,950,486.92
1.4.1	Авсан хүү (+)	817,887,395,544.89	443,595,210,541.06
1.4.2	Төлсөн хүү (-)	(540,229,937,944.92)	(290,644,954,901.24)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(65,501,487,672.88)	(26,178,305,152.90)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	(924,843,036.93)	-
1.4.5			
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(562,693,282,179.18)	(302,433,950,337.78)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	42,860,457,358.24	13,537,349,466.95
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	55,316,844.16	6,349,466.95
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	1,843,128,923.27	870,200,000.00
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт	-	-
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	5,179,949,503.94	2,660,800,000.00
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	35,782,062,086.87	10,000,000,000.00
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(67,577,402,056.01)	(60,634,015,169.71)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,453,231,393.26	6,606,811,647.79
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	942,570,662.75	372,804,149.79
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	49,181,600,000.00	53,654,399,372.13
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(24,716,944,697.77)	(47,096,665,702.77)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,110,066,654,632.65	656,282,311,276.00
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	1,110,066,654,632.65	656,282,311,276.00
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.5	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(696,420,645,813.40)	(393,077,123,486.77)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	640,541,288,283.97	356,462,996,987.34
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	2,112,693,518.41	173,666,076.10
3.2.5	Төлсөн ногдол ашиг	47,332,334,871.00	31,495,403,310.00
3.2.6	Бусад	6,434,329,140.02	4,945,057,113.33
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	413,646,008,819.25	263,205,187,789.23
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(173,764,218,057.70)	(86,325,428,251.32)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,895,273,697,466.20	1,721,509,479,408.51
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,721,509,479,408.51	1,635,184,051,157.19

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Г.ЦЭВЭГЖАВ

Р.ТАМИР



2026 оны Зургаадугаар сар 30

(Төгрөгөөр)

№	Дансны нэр	Эхний үлдэгдэл /2025.12.31/	Эцсийн үлдэгдэл /2026.06.30/
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг	302,153,341,304.55	291,015,102,856.28
2	Барьцаа хөрөнгө	7,428,193,767,606.55	8,834,378,634,715.45
3	Тэнцлээс хассан хөрөнгө	82,476,729,281.68	83,800,173,431.97
4	Дериватив санхүүгийн хэрэгсэл	2,071,972,007,901.70	2,267,164,390,753.65
5	Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө	-	-
6	Барьцаанд тавьсан хөрөнгө	-	-
7	Тэнцлийн гадуурх бусад дансууд	518,232,604,991.30	496,186,278,934.57
Нийт		10,403,028,451,085.8	11,972,544,580,691.9

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ✓

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ТАМИР